Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Суралцагчийн үнэлгээний хэлтэс

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 1.1. | Бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх арга хэмжээг үндэсний хэмжээнд | - | - | - | - | | Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх ажилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр 8 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаа. Дундаж биелэлт 93.75 хувь байна. Мөн сургуулийн өмнөх болон ерөхний боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаа. | 93.75 % | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | удирдлага зохион байгууллалтаар хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх | | | | | | | | |
| 1.1.4 | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдийн хөгжлийн үнэлгээ хийж буй байдал, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. | - | Хамрагдсан цэцэрлэгийн тоо | - | 10 | 10 | Хүүхдийн хөгжлийн үнэлгээ хийж буй байдал, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх хүрээнд 22 цэцэрлэгийн 45 багшийг хамруулан дараах ажлыг гүйцэтгэлээ. 1. 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр нийслэлийн Сүхбаатар дүүргийн 160 дугаар цэцэрлэгийн багш нарын хүүхдийн хөгжлийн үнэлгээ хийж буй байдалтай танилцаж, зөвлөн туслав. Тухайн цэцэрлэгийн багш нарын хүүхдийн хөгжлийн үнэлгээ хийж буй явцад давуу тал, анхаарах зүйлийг хэлэлцсэн. 2. Чингэлтэй дүүргийн 275 дугаар цэцэрлэгийн Энхтүвшин багштай ахлах "А" бүлгийн сургалт, үйл ажиллагаа, явцын үнэлгээ хийж буй байдалтай танилцаж зөвлөн туслав. Тухайн багшийн явцын үнэлгээ хийж буй туршлагыг туршилтын 18 цэцэрлэгийн ахлах бүлгийн багш нарт онлайн сургалтаар дамжуулан танилцуулж хэлэлцүүлэв. 3. 2025 оны 03 дугаар сарын 17-ноос 18-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын 1 дүгээр цэцэрлэг дээр ажиллаж хүүхдийн хөгжлийн үнэлгээ хийж буй байдалтай танилцаж, зөвлөн туслав. 4. БСҮХ-ийн ЭША Г.Монголхатан, БҮТ-ийн мэргэжилтэн М.Бямбасүхтэй нартай хамтран "Сургуулийн өмнөх болон бага боловсролын залгамж холбоо, асуудал, шийдэл - 2025" эрдэм шинжилгээний хуралд оролцож, илтгэл хэлэлцүүлэв.<br>Хавсралт: 2 файл | 100 % | 100 % |
| 1.1.5 | Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын | Батлагдсан төсвийн хүрээнд | - Хамрагдсан сургуулийн тоо - Суралцагчийн тоо - | -6 (сургууль) - 291 (суралцагч) - 84 (ахицы | -7 (сургууль) - 509 (суралцагч) | -7 (сургууль) - 509 (суралцагч) -85 (ахицын | Үйлдвэр урлалын Политехник коллежид явцын үнэлгээнд зөвлөн тусалсан. Мэргэжлийн болон техникийн боловсролын 7 сургалтын байгууллагад "Pearson BTEC" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Хөтөлбөрийг тус сургалтын байгууллагуудын 509 суралцагч судалсан байна. Анги дэвших төгсөлтийн шалгалтад нийслэл, орон нутгийн суралцагчид ирц бүрэн 100% хамрагдлаа. Хөтөлбөрийг Өмнөговь, Ховд, Дорнод, Хөвсгөл, Дархан аймгууд болон Үйлдвэр урлал, Техник технологийн политехник коллежууд бүгд амжилттай хэрэгжүүлсэн. Нэгдсэн | 90 % | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагад олон улсын PEARSON BTEC хөтөлбөрийн үнэлгээг зохион байгуулахад зөвлөн тусална. | | Ахицын хувь | н хувь) | | хувь) | тайланг боловсруулж , үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээг холбогдох газарт мэдэгдсэн.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.1.6 | Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний загвар аргачлал боловсруулна. | - | - Судалгааны тоо - Үнэлгээний загвар аргачлалын тоо | - | 1 /судалгаа/ | 1 /аргачлал/ | Кембриджийн зөвлөх багаас бага боловсролын 1-2 дугаар ангийн шинэчилсэн хөтөлбөрийг үнэлэх ажлыг 4 бүлэг 24 асуулгын хүрээнд хийж гүйцэтгээд байна. Тус үнэлгээг орчуулж дүгнэлт хийх ажлыг эхлүүдээд байна.<br>Хавсралт: 5 файл | 70 % | 70 % |
| 1.1.7 | СӨБ, ЕБС, МбТБ, Дээд боловсролын салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээ | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 100 | Дараах журмын төсөлд саналаа өгч хэлэлцүүлсэн ба хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн ажилласан. 1.2025.02.07-ны өдөр БЯ-нд зохион байгуулагдсан "Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах журам"-ын төслийн хэлэлцүүлэгт оролцож санал өгсөн. 2. БСШУС-ын сайдын 2020 оны А/280 дугаар тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлэх журам”-ын төсөлд санал өгөв. 3.Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны “Журам батлах тухай” А/187 дугаар тушаал, 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/386 дугаар тушаал, 2023 оны “Улсын олимпиад зохион байгуулах журам батлах тухай” А/420 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн багш, суралцагчдын дунд зохион байгуулах | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | р журмын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. | | | | | | "Улсын олимпиад зохион байгуулах журам"-уудын хэрэгжилтэд арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн ажиллаа. 4.Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурт "Багшийн хичээл ажиглалт"-ын талаар шалгуур үзүүлэлт оруулах, суралцагчийг үнэлэх хэсэгт шалгуурын хувь, жинг багасгах тухай. 5. 2025 оны 2 дугаар сарын 7-ы өдөр "Цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам"-ын төсөлд санал өгөв.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1. 1. 8 | Судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүдэд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллана. | - | Цахим сургалтын тоо | - | 2 | 2 | 1. Аймаг, Нийслэлийн боловсролын газрын Байгалийн ухаан /Хими, Физик, Биологи, Газарзүй/ хариуцсан арга зүйч, мэргэжилтнүүдэд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, цаг үеийн мэдээллээр хангах, харилцан санал солилцох зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдөр цахим уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар байгалийн ухаан хичээлээр түүвэрт сонгогдсон багш нарыг хариуцлагатай оролцуулах, Химийн гүйцэтгэлийн үнэлгээ-2024 оны үр дүнгийн талаар ярилцах, 2025 онд БУ-ны сургалтын чанарыг сайжруулах талаар хийгдэх үйл ажиллагаа, БУ-ын сургалтын нөхцөл байдлын талаар танилцуулах, мэдээлэл солилцон хэлэлцсэн. 2. 2025 оны 05 сарын 09-ний өдөр аймаг, нийслэл, дүүргүүдийн судлагдахуун хариуцсан 21 аймгийн мэргэжилтнүүдэд онлайн уулзалтыг зохион байгууллаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээллийг 2 удаа өгч, дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Бусад гадаад хэлний мэргэжилтнүүдэд чатаар болон утсаар мэдээлэл хүргэн ажиллалаа. 3. "Монголын түүх, соёл, ёс заншил" хичээлийн хөтөлбөрийг судалсан. Хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, арга зүйн зөвлөмж боловсруулах ажлыг их дээд сургуулийн багш нартай хамтран хийж байна. 3. Цаг үеийн мэдээллээр 4 дүгээр сард захирлуудад салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, цахим хурлыг зохион байгуулж журмын хэрэгжилтэд зөвлөмж өгсөн. | 100 % | 100 % |
| 1. 1. 9 | "Ерөнхий боловсролын сургуулийн номын санд | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 100 | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 3 дугаар сарын 20-ы өдрийн ”Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/141 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан /2.2.5/ “Ерөнхий боловсролын сургуулийн номын санд ном, хэрэглэгдэхүүн нийлүүлэх, суралцагчдын унших чадварыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх” хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд нийслэлийн ерөнхий | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ном, хэрэглэгдэхүүн нийлүүлэх, суралцагчдын унших чадварыг хөгжүүлэх" хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, хамтран ажиллана. | | | | | | боловсролын 4, 18, 102, 113, 119, 139, 146, 154, Оюуны-Ундраа, Сэлэнгэ, Хүдэр, Дундговь аймгийн Сайнцагаан, Эрдэнэдалай сумын сургуулиудад очиж, номын санчтай уулзалт хийн, судалгаа авч, номын сангаар үйлчлүүлж буй суралцагчтай ном унших ач холбогдлын тухай ярилцлага зохион байгуулсан бөгөөд хэрэгжилтийн талаар судалгаа авч ажиллаа. Судалгааны үр дүнгээс үзэхэд хөтөлбөр хэрэгжүүлснээс хойш суралцагчдын унших чадвар 46,6%-иар нэмэгдсэн байна. Хөтөлбөрийн багтай хамтран "Чанга уншлагаар дамжуулан суралцах чадварыг хөгжүүлэх" сургалтыг 2 дугаар сарын 24-ний өдөр амжилттай зохион байгуулж, тус хөтөлбөрийг хэрэгжүүлж буй сургуулиудын сайн туршлагыг зураг болон видео бичлэгээр байгууллагын цахим хуудсаар түгээн олны хүртээл болголоо. Мөн хөтөлбөрийн багийн боловсруулсан "Литерасийг эрхэмлэх соёлыг сургуулиудад хэрхэн төлөвшүүлэх вэ?" 4 бүлэг бүхий 152 хуудас 950 ширхэг эмхэтгэлийг төрийн өмчийн ерөнхий боловсролын 733 сургуульд түгээж, линкийг байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулсан. /https://drive.google.com/file/d/1wVH4jpWrV2bW7-PvKPHX1803Sudzbfxs/view?fbclid=IwY2xjawKuatJleHRuA2FlbQIxMABicmlkETFCc3NEYTVReDNJTnJZMVJYAR4px52sp3-OzyTKU23H65957QoAOw6G9KCQRF3_CrfAnTh6pKRvBqPvn95rRA_aem_HGovw3tPRbiR9qpmHSurzg/<br>Хавсралт: 9 файл | | |
| 1.1.10 | Монгол хэл, бичгийн сургалтад ахиц гаргахад дэмжлэг үзүүлж, сургалт зохион байгуулна. | - | Сургалтад хамрагдсан багшийн тоо | - | 250 | 250 | 2023, 2024 оны монгол хэл бичгийн шалгалтын үр дүнг Боловсролын үнэлгээний төвөөс илгээсэн авч анализ хийн, 2025 оны 5 дугаар сарын 23-ы өдөр хөндлөн багийн мэргэжилтэнтэй хамтран 153 багш, мэргэжилтэнд цахимаар сургалт зохион байгуулсан. Сургалтаар тус шалгалтын талаарх ерөнхий мэдээлэл, өмнөх оны төгсөгчдийн үнэлгээний харьцуулалт, гүйцэтгэлийн хувийн интервал, гүйцэтгэлийн хувийн тархалт, аймаг, дүүргийн гүйцэтгэл, дундаж, агуулгын гүйцэтгэл, дүгнэлтийг танилцуулан, цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар зөвлөмж өглөө. Ингэснээр багш нарын хамтарсан хичээл бэлтгэх, хичээлийн агуулгад суурилсан сорил, дасгал ажил боловсруулах, хичээлд идэвхтэй суралцах орчныг бүрдүүлэх, сургалтын явцын оношилгооны аргуудыг ашиглан сурагч бүрийн ахицыг тогтмол хянаж, дутагдалтай чадварыг хөгжүүлэхэд түлхэц болсон. | 90 % | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хавсралт: 3 файл | | |
| 1. 1. 11 | Төрөлжсөн ахлах сургуульд байгалийн ухааны хичээлийг англи дээр зохион байгуулах ажлыг хэрэгжүүлнэ. | - | Хэрэгжилтийн хувь | - | 100 | 100 | Боловсролын сайдын 2025 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А/188 дугаар тушаалаар "Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэл" батлагдсаны дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан танилцуулсан. Энэ хүрээнд Боловсролын яаманд зохион байгуулагдсан 1 удаагийн уулзалтад оролцож санал солилцсон. Мөн төрөлжсөн ахлах сургуульд байгалийн ухааны хичээлийг англи хэл дээр зохион байгуулах боломжийг илрүүлэх судалгааг ахлах ангид хими, физик, биологи, газарзүйн хичээл заадаг багш нараас авсан. Судалгаа нь нийт 21 асуулга бүхий ахлах ангид хичээл заадаг байгалийн ухааны багш нарын товч мэдээлэл, хичээлээ англи хэлээр зохион байгуулах боломжийг илрүүлэх гэсэн 2 хэсгээс бүрдсэн бөгөөд нийт 1184 багш нар хамрагдсаны 38.7 хувь нь хичээлийг англи хэлээр орох боломжтой, англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх шаардлагатай гэсэн байна.<br>Хавсралт: 2 файл | 90 % | 90 % |
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 3. 1. | Бүх түвшний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж | - | - | - | - | | Зорилтын хүрээнд 3 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаа. Дундаж биелэлт 90%. Бүх түвшний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. | 90 % | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дүгнэх, холбогдох талуудад хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар мэдээлэл өгөх | | | | | | | | |
| 3.1.1 | Цахим системд суурилан суралцагчийн сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах ажлыг зохион байгуулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | “СУРААД” цахим системд хамрагдсан сургууль, суралцагчийн тоо | -23 (сургууль) - 11,000 (суралцагч) | -3 (сургууль) - 150 (суралцагч) | -25 (сургууль) -1250 (суралцагч) | Боловсролын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/177 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн суралцагчийн сурлагын хоцрогдол арилгах, математикийн ур чадварын хөгжлийг дэмжих цахим сургалтыг 2024-2025 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх төлөвлөгөө” батлагдсан. Тус тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Математикийн хичээлийг бие даан суралцах, хоцрогдол арилгах цахим платформ /Suraad.mn/ -ын зохиогчийн эрхийг эзэмшигч, үндэслэгч “Сураад” ХХК-тай хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд Улаанбаатар хотын 3, Булган аймгийн 7, Хөвсгөл аймгийн 8, Орхон аймгийн 7 нийт 25 сургуулийн 176 багш, 11324 сурагч Сураад цахим платформд ажилласан бөгөөд "Сураад" ХХК-аас ирүүлсэн тайланг дүгнэх ажил хийгдэж байна.<br>Хавсралт: 1 файл | 70 % | 90 % |
| 3.1.2 | Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг сургалты | Батлагдсан төсвийн хүрээнд | Хамрагдсан цэцэрлэгийн тоо | 18 | 18 | 10 | Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг сургалтын байгууллагын түвшинд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг багаараа боловсруулан хэрэгжилтийн ханган ажиллаа. БСҮХ-тэй хамтран сургалтын хөтөлбөр туршин хэрэгжүүлж буй цэцэрлэгийн арга зүйч, багш нарт танхимын сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад 23 багш ажилтан хамрагдсан. "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын төлөвлөгөө, суралцахуйн удирдамж, багшийн гарын авлага"-ыг турших ажлын хүрээнд БЯ-ны СӨБХ, БСҮХ, БҮТ, БЕГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран нийслэлийн СХД-ийн 110-р цэцэрлэг, ЧД- | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | н байгууллагын түвшинд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. | | | | | | ийн 275-р цэцэрлэг, 2025.02.10-14-ний өдрүүдэд Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 2-р цэцэрлэг, Цэнгэл сумын 1-р цэцэрлэгт тус тус зөвлөн тусалж, орон нутгийн боловсролын газрын мэргэжилтэн, багш нарт хөтөлбөрийн шинэчлэлийн талаар мэдээлэл хүргэсэн. Мөн 2025 оны 03 дугаар сарын 17-ноос 21-ний өдрүүдэд Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын 1-р цэцэрлэг, нийслэлийн СХД-ийн 110 дугаар цэцэрлэг дээр багаараа удирдамжийн дагуу ажиллаж, ажиглалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулж, хөтөлбөрийн сайжруулалтын талаар ажиллаа.<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.1.3 | Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, багшийн гарын авлагын туршилтын эх зохиох, хянах багт хамтран ажиллана. | Батлагдсан төсвийн хүрээнд | - Хамтран боловсруулсан хөтөлбөр - Гарын авлагын тоо | -1 (хөтөлбөр)<br>-1 (гарын авлага) | -1 (гарын авлага) | -1 (хөтөлбөр) | 1.Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрийн туршилтын хүрээнд 2, 3, 4 дүгээр сард турших багшийн гарын авлагыг ахлах бүлгийн багаараа хамтран боловсруулж, туршилтын багш нарт хүргэсэн. 2. "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын төлөвлөгөө, суралцахуйн удирдамж, багшийн гарын авлага"-ыг туршин хэрэгжүүлж буй цэцэрлэгийн арга зүйч, хөгжим, биеийн тамир, ахлах бүлгийн багш нарт "Төсөлд суурилсан суралцахуй"-г хэрэгжүүлэх талаар онлайн уулзалтыг 2025.02.06-ны өдөр зохион байгууллаа. Цахим уулзалтад 72 оролцогч хамрагдсан.<br>Хавсралт: 3 файл | 100 % | 100 % |
| 3.2. | Сургалтын хөтөлбөр, үнэлгээн | - | - | - | - | | Зорилтын хүрээнд 6 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг бүрэн хангаж биелүүлэв. Энэ хүрээнд улсын болон олон улсын олимпиад, олон улсын PISA үнэлгээ, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн ур чадвар, чадамжийн үнэлгээг амжилттай зохион байгуулсан. | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ий хэрэгжил тэд дэмжлэг үзүүлэх | | | | | | | | |
| 3.2.1 | Улсын олимпиадыг зохион байгуулж, үр дүнг тайлагнана. | Батлагдсан төсвийн хүрээнд | Гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | 100 | Улсын олимпиадыг 12 судлагдахууны хүрээнд дунд, ахлах анги, багшийн гэсэн 3 төрлөөр Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны А/420 дугаар тушаалаар батлагдсан “Улсын олимпиад зохион байгуулах журам"-ын дагуу амжилттай зохион байгуулсан. Энэ удаагийн олимпиадад 21 аймаг, 9 дүүрэг, бүс нийслэлээс шалгарсан 1541 суралцагч, 630 багш нар оролцсон байна. Суралцагч төрөлд: • Алтан медаль 43 буюу оролцогчдын 3% • Мөнгөн медаль 105 буюу оролцогчдын 7% • Хүрэл медаль 154 буюу оролцогчдын 10% • Тусгай байр 108 буюу оролцогчдын 8%-ийг эзэлж нийт оролцогчдын 28% буюу 410 суралцагч болзол, шалгуурыг ханган шагналт байранд шалгарсан байна. Багш төрөлд: • Алтан медаль 17 буюу оролцогчийн 3% • Мөнгөн медаль 36 буюу оролцогчийн 6% • Хүрэл медаль 49 буюу оролцогчийн 8% • Тусгай байр 56 буюу оролцогчийн 9%-ийг эзэлж, нийт оролцогчийн 26% буюу 158 багш бозол, шалгуурыг ханган шагналт байранд шалгарсан байна. Энэхүү ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны А/36 дугаар тушаалаар баталж, 545,692,000 төгрөгийг зарцуулсан байна.<br>Хавсралт: 6 файл | 100 % | 100 % |
| 3.2.2 | Олон улсын олимпиадад оролцогчдын бэлтгэл ажлыг хангаж ажиллана. | Батлагдсан төсвийн хүрээнд | Гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | 100 | Манай улс 2024-2025 оны хичээлийн жилийн улсын төрөлжсөн олимпиадаас шалгарсан сурагчдыг олон улсын түвшинд зохион байгуулагддаг математик, физик, хими, биологи, газарзүй, мэдээлэл зүй, охидын математик, европын физик, азийн физик, хиймэл оюун ухаан, техник технологийн (нисэх) 11 чиглэлийн олимпиадад оролцуулах бэлтгэл ажлыг олимпиадын хороодтой хамтран ажиллаж байна. Боловсролын ерөнхий газрын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн “Олон улсын олимпиадын зардал гаргах тухай” А/53 дугаар тушаалаар Олон улсын 11 чиглэлийн олимпиадад 27 багш, 50 сурагч оролцох нийт 658,455,500 төгрөгийн зардлыг батлуулсан. 2025 оны хагас жилийн байдлаар улсаа төлөөлөн 4 сурагч, 3 багш Европын Охидын Математикийн 14 дүгээр Олимпиад Бүгд Найрамдах Косово улсын нийслэл Приштина хотод 2025 оны 4 | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дүгээр сарын 11-17 өдрүүдэд, Азийн физикийн XXV олимпиад 8 сурагч, 3 багш Саудын Арабын хаант улсад 2025 оны 5 дугаар сарын 4-өөс 12-ны өдрүүдэд тус тус зохион байгуулагдсан олимпиадад амжилттай оролцсон байна.<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.2.3 | Цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хөтөлбөрт хамрагдсан суралцагчдын сурлагын ахицын хувь | 17 | 19 | 21 | Англи хэлний цахим хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 9 зорилт, 32 арга хэмжээтэйгээр боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаа. Тайлант хугацаанд 11 арга хэмжээг хяналтад аван бүрэн хэрэгжүүлсэн. /биелэлтийг хавсаргав/ Энэ хүрээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, цахим системийн ашиглалтад хяналт тавих зорилгоор 21 аймгийн Боловсролын газарт цахим системд нэвтрэх эрх олгосон нь нэгж дээрх хяналтыг сайжруулсан. Мөн Английн Элчин сайдын яамны санхүүжилтээр Баян-Өлгий, Баянхонгор, Сүхбаатар аймгийн англи хэлний багш нарт эрчимжүүлсэн сургалт зохион байгуулж, аймаг тус бүрд 30 ширхэг таблет, зөөврийн компьютерыг олголоо. Англи Улсад зохион байгуулагдсан Олон улсын англи хэлний багш нарын чуулга уулзалтад хэлтсийн мэргэжилтэн Ч.Энхчимэгийг хамруулж, мэдлэг чадварыг нь дээшлүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг бодитой үнэлэх, тандалт хийх зорилгоор Боловсролын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу III-IV ангид туршин хэрэгжүүлж буй төрийн өмчийн 11 ЕБС дээр ажиллалаа. Энэ хүрээнд тус сургуулийн удирдлагууд, багш нартай уулзалт ярилцлага хийж, III-IV ангид заадаг 11 багшийн хичээлд хичээлийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн 56 багшид хөтөлбөрийн хэрэгжилт, платформын хэрэглээний талаар шаардлагатай мэдээллийг өгч мониторинг хийн, гарсан асуудлыг хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх Ажлын хэсгээр хэлэлцэн шийдвэрлэж, зөвлөмж өгөн ажиллаа. Мөн тус ангиудад хичээл зааж буй багш нарын сонголтоор багшийн гүйцэтгэлийн үнэлгээний түүвэрт хамруулан бичгийн шалгалт авсан бөгөөд БҮТ шалгалтыг засах, үнэлэх ажлыг гүйцэтгэж байна.<br>Хавсралт: 7 файл | 100 % | 100 % |
| 3.2.4 | Олон улсын “PISA-2025” | - | Гүйцэтгэлийн хувь | - | 100 | - | Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хүрээнд БҮТ-тэй хамтран “PISA-2025” олон улсын үнэлгээний зохион байгуулалтыг хариуцан ажиллаа. Энэ хүрээнд үнэлгээг ерөнхий боловсролын сургуульд хэрхэн зохион | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангахад хамтран ажиллана. | | | | | | байгуулах, бэлтгэлийг хэрхэн хангах талаар чиглэл өгөх сургалт уулзалтыг аймаг нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтэс холбогдох албан тушаалтан, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерүүдийг хамруулан 2 удаа зохион байгуулж, түүвэрт сонгогдсон сургуулийн 15 настай сурагчдыг бүрэн хамруулах талаар чиглэл өгч ажилласан. Мөн үнэлгээ гардан зохион байгуулах, хяналт тавих комиссын бүрэлдэхүүнд 25 Хянагч багш, 25 тоног төхөөрөмж, сүлжээ хариуцсан мэргэжилтэн, сургууль бүр дээр шалгалт зохион байгуулагч, Мэдээлэл, технологийн багш 382 хүн, БГ, хэлтсүүдээс үнэлгээний мэргэжилтэн ажиллуулж хүний нөөцийн дэмжлэг үзүүлсэн. “PISA-2025” үнэлгээг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 16-ны өдрийн хооронд зохион байгуулсан бөгөөд үнэлгээнд нийслэлийн 91, орон нутгийн 81 ерөнхий боловсролын сургууль, нийслэл, орон нутгийн нийт 19 мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нийт 191 сургалтын байгууллагын 15 настай 7446 сурагч түүвэрт сонгогдсоноос 7142 сурагч буюу 95.9%-ийн ирцтэй шалгагдаж, байгалийн ухааны нийт хамрагдах 1343 багшаас 1329 багш буюу 99.0%-ийн ирцтэйгээр хамрагдаж, амжилттай зохион байгуулсан.гүйцэтгэлийг үнэлэх ажил хийгдэж байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 3.2.5 | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/128 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн болон | - | -Зохион байгуулсан сургалтын тоо -Зөвлөмжийн тоо | 3 (сургалт) | 1 (сургалт) | -1 (сургалт) -1 (зөвлөмж) | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/128 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам“-ын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга, мэргэжилтэн, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдлага, багш нарыг хамруулсан сургалт, уулзалтыг зохион байгуулж, чиглэл өгч ажилласан. Энэ хүрээнд: 1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын өвлийн төгсөлт буюу 2025 оны 1 сард 47 сургуулийн 6577 төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлэхэд 90.1 хувь нь чадамжтай үнэлэгдсэн. Эдгээр төгсөгчид давхардсан тоогоор 328 чиглэлийн мэргэжил эзэмшсэн бөгөөд холбогдох тайлан, мэдээг Боловсролын яамны мэргэжлийн болон техникийн боловсролын газарт хүргэж ажилласан. 2. Мэргэжлийн | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам“-ын хэрэгжилтийг ханган ажиллана. | | | | | | болон техникийн боловсролын 2024-2025 оны хичээлийн жилийн хаврын төгсөлтийн урьдчилсан судалгааг авч Боловсролын яамны мэргэжлийн болон техникийн боловсролын газарт болон холбогдох газар хэлтэс, нэгжид хүргэж ажилласан бөгөөд төгсөлтийн үнэлгээ зохион байгуулах, тайлан мэдээг ирүүлэх чиглэлийг сургуулиудын удирдлага, боловсролын газрын мэргэжилтэнд хүргэж ажиллалаа. Энэхүү судалгаагаар 2024-2025 оны хичээлийн жилийн хаврын төгсөлтөөр 65 сургалтын байгууллагын 552 мэргэшлээр /давхардан тоогоор/ 11557 суралцагч төгсөх бөгөөд эдгээр төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлэх ажил зохион байгуулагдаж байна. | | |
| 3.2.7 | Эрдэм шинжилгээний хурал хамтран зохион байгуулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | - Хамтран ажилласан байгууллагын тоо - Хэрэгжилтийн хувь | -4 (хамтран ажилласан байгууллагын тоо) - 100 | -4 (хамтран ажилласан байгууллагын тоо) - 100 | - | Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Монгол улсын боловсролын их сургууль, Монгол улсын их сургуулийн захирлын хамтарсан А/90, А/68, А/14, А/118, А/23 дугаар тушаалыг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр боловсруулсан. Ажлын хэсэг 37 гишүүний бүрэлдэхүүнтэй. Салбар хуралдааны чиглүүлэгчээр 14 эрдэмтэн доктор ажилласан. “Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл, арга зам- 2025” эрдэм шинжилгээний хуралд Удирдлагын академи, СЭЗИС, ШУТИС, Дорнод их сургууль гэх мэт улс хувийн их сургуулиуд, эрдэмтэн судлаач нар оролцсон. Easy chair системээр нийт 94 өгүүлэл хүлээн авч Б.Лхагвабаяр, Д.Сумъяа болон эрдэмтэд шүүмж хийж, сайжруулах санал зөвлөмжийг өгсөн. Оюутны илтгэлийн шүүгчээр дэд профессор Нямгэрэл, Д.Сумъяа, доктор | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Мөнхсайхан ажиллаж, шагналт байрыг шалгаруулж 6 оюутанд батламж гардуулсан. Судалгааны объект нь Боловсрол дахь хиймэл ухааны чиг хандлага, Технологийн дэвшил дэх багшлахуй ба суралцахуй болон боловсролын ирээдүйн чиг хандлагыг хөндсөн асуудлууд хэлэлцэгдлээ. Хуралдаан 3 танхимд зэрэг явагдаж, цахим дамжуулалтыг хийсэн. Цахим хуралд тавин мянга орчим олон нийт хамрагдсан. "Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, ахиц анхаарах зүйл сэдвээр" сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газрын дарга Л.Лхагвабаяр судалгааны ажлаа танилцуулсан. Хурлын дараах зөвлөмжийг боловсруулсан. Илтгэлийн хураангуйг 40 хуудас бүхий 300 ширхэг ном болгон хэвлүүлсэн. Монголын болоод олон улсын сэтгүүлд эрдэм шинжилгээний бүтээлээ танилцуулах боломжийг хангаж ажилсан. | | |
| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 4.1. | Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллаж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах | - | - | - | - | | Тус зорилтын хүрээнд 4 арга хэмжээ төлөвлөн бүрэн хангаж биелүүлсэн. Дундаж хэрэгжилт 100%. Энэ хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 33 албан бичиг, 422 өргөдлийг хянан шийдвэрлэж, хуулийн хугацаанд хариу мэдэгдсэн. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 5 чиглэлээр архивын нэгж үүсгэн хүлээлгэн өгсөн байна. | 100 % | 100 % |
| 4.1.1 | Авлигын эсрэг хууль, нийтийн албанд | - | ХАСХОМ мэдүүлгийн тоо | 1 | 1 | - | Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т зааснаар хөрөнгө орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд багтаан мэдүүлж,.ашиг сонирхлын зөрчил үүсгээгүй, шударга | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ. | | | | | | хариуцлагатайгаар ажилсан. | | |
| 4.1.2 | Боловсролын ерөнхий газрын даргын шуурхай хурал, Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газрын | - | Биелэлтийн хувь | - | 100 | 100 | Нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Боловсролын яам болон БЕГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хэрэгжилтийг ханган ажилласан. 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр “Таблеттай багш хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц, сургалтын ухаалаг багцын хэрэглээний талаар танхим болон цахим хосолсон сургалт, хэлэлцүүлгийн дадлага ажлыг чиглүүлэн ажиллав. Сургалт, хэлэлцүүлэгт БЕГ, БҮТ, БСҮХ, НБГ-ын мэргэжилтнүүд аймаг, дүүргийн Боловсролын газар, хэлтсийн Сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан ахлах арга зүйч, мэргэжилтнүүд, эрхлэгч, арга зүйч, багш нарын төлөөлөл 73 хүн оролцогч хамрагдав. Мэргэшүүлэх сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 05-ны өдрүүдэд нийт 21 аймгийн 82, нийслэлийн 4, дүүргийн 5, нийт 91 мэргэжилтнүүдэд зохион байгуулсан. Сургалтад Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөлтийн үнэлгээ зохион байгуулах арга зүй, үнэлгээний баталгаажуулалт хийхэд баримтлах зарчим, тавигдах шаардлага, суралцагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг үнэлж, баталгаажуулах арга зүй, | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | даргын шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | | | | аргачлалыг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулсан. Хавсралт: 1 файл | | |
| 4.1.3 | Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу | - | Хадгаламжийн нэгжийн тоо | 4 | 9 | - | Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн БНШК-ын 2024 оны 12 дугаар сарын 30 ны өдрийн 01 дугаар хурлаар хянан хэлэлцэн зөвшөөрсөн хавсралтын дагуу 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаар: 1. “Амьдралын мод” хөтөлбөр хэрэгжүүлэх явцад цэцэрлэгийн үйлчилгээг сайжруулах ажлын хэрэгжилт, зөвлөн туслах үйл ажиллагааны баримт бичиг 2. “Амьдралын мод” хөтөлбөр хэрэгжүүлэх явцад хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлсэн ажлын хэрэгжилт, зөвлөн туслах үйл ажиллагааны баримт бичиг 3. 421 иргэний 1805 хуудас бүхий боловсролын баримт бичгийг баталгааны хуудас, дотоод товьёг, баримт ашиглалтын хуудсанд дугаар үүсгэж 4.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 3 дугаар сарын 20-ы өдрийн ”Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/141 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан /2.2.5/ “Ерөнхий боловсролын сургуулийн номын санд ном, хэрэглэгдэхүүн нийлүүлэх, суралцагчдын унших чадварыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх” хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх 2 боть баримт бичгийг 2025 оны 1 дүгээр сарын 17-ы өдөр хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хариуцсан мэргэжилтэнд өгч, хадгалуулсан. 5. Суралцагчийн үнэлгээний хэлтсийн албан хаагчдын хагас , бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан - 216 хуудас,Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн “Журам батлах тухай” А/187 дугаар тушаалаар батлагдсан “Гадаад улсын, эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах тохиолдолд суралцагчийн эзэмшсэн | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | архивын нэгж болгон хадгалуулна. | | | | | | чадамжийг үнэлж, дүйцүүлэх, багц цаг тооцох журам” - 51 хуудас материалыг тус тус архивын нэгж үүсгэн хүлээлгэн өгөв. | | |
| 4.1.4 | Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэнэ. | - | Биелэлтийн хувь | 100 | 100 | 100 | Тайлант хугацаанд хэлтэст 32 албан бичиг 422 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж хариуг мэдэгдэж ажиласан. | 100 % | 100 % |

*Үнэлсэн:* .........................

......................................... ......................... /................................/

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*

*Тайлагнасан:* .........................

.......................................... ......................... /................................./

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*